МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 12 өдөр Дугаар А/331 Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIII хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар тогтоол, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIV хуралдааны 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө болон тодотголд тусгагдсаны дагуу шинээр газар эзэмшиж байгаа төрийн байгууллагын 7 нэгж талбарын нийт 5.7609га /57609м²/ газрыг хавсралтад дурдсанаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмшиж байгаа төрийн байгууллагын дарга нартай гэрээ байгуулж, газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

671 0107 02

Аймгийн Засаг даргын 2023 оны
..06. дугаар сарын ..12..-ны өдрийн
А/..331... дүгээр захирамжийн хавсралт

ШИНЭЭР ГАЗАР ЭЗЭМШИХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистр	Төлөвлөгөөний нэгж талбарын дугаар	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газрын зориулалт	Газар эзэмшүүлэх хугацаа	Тайлбар
1	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газар /РД:9070192/	3259294	14-р баг	3839	Төрийн захиргааны байгууллага	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
2	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газар /РД:9070192/	3259274	14-р баг	4486	Төрийн захиргааны байгууллага	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
3	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын тамгын газар /РД:9070192/	3405844	13-р баг	2401	Биеийн тамир, спортын байгууллага	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
4	Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /РД:4125622/	3268745	8-р баг	785	Төрийн захиргааны байгууллага	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
5	Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /РД:4125622/	3268744	8-р баг	338	Төрийн захиргааны байгууллага	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших

6	Хөвсгөл аймгийн хөгжимт драмын театр /РД:9070524/	3405841	13-р баг	46495	Урлаг, соёлын байгууллага	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших
7	Хөвсгөл аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /РД:4125444/	2997606	8-р баг	3104	Төрийн захиргааны байгууллага	15	Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу шинээр газар эзэмших

Нийт талбайн хэмжээ:57609м^2

----------o0o----------